



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/85

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/829 дүгээр захирамж, Газрын дүрмийн 2.5.3, 3.1.2, 3.1.9 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилго бүхий “Талын түмэн адуу” арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлал, хот орчмын өвлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлахаар ирсэн БНХАУ-ын хэвлэл мэдээллийн ажилтнууд, гэрэл зурагчдын багийг Улаанбаатар хотод ажиллахад дэмжлэг үзүүлэн ажиллахыг Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс /Д.Жавхлан/-т даалгасугай.

2. БНХАУ-ын хэвлэл мэдээллийн ажилтнууд, гэрэл зурагчдаас бүрдсэн багийг Улаанбаатар хотод ажиллах нөхцөлөөр хангахад шаардагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. БНХАУ-ын хэвлэл мэдээллийн ажилтнууд, гэрэл зурагчдаас бүрдсэн багийг Улаанбаатар хотод ажиллах нөхцөлөөр хангахад шаардагдах хөрөнгө болох 4,347,500 /дөрвөн сая гурван зуун дөчин долоон мянга таван зуун/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

D. Batsukh

Д.БАТСҮХ



1150500317

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 11 сарын 13
өдрийн 135 дугаар тушаалын хавсралт



БНХАУ-ЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БОЛОН ГЭРЭЛ ЗУРАГЧДААС БҮРДСЭН
БАГИЙГ УЛААНБААТАР ХОТОД АЖИЛЛАХ НӨХЦӨЛӨӨР ХАНГАХАД
ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

2017 оны 11 сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ	Тооцоо хийх хэлбэр
1	Зочид буудал	15 хүн	3 хоног	70 000	3 150 000	Бэлнээр
2	Зочдын хоол	15 хүн	3 хоног	25 500	1 147 500	Бэлнээр
3	Шатахууны зардал	Км	150	50 000	50 000	Бэлнээр
НИЙТ ДҮН					4 347 500	

--oo0oo--

ХЯНАСАН:
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

Б. БАТБААТАР

ТӨСӨВ ЗОХИОСОН:
ХАМТЫН АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

З. ОЮУНШҮР